



## Алсын хараа

“Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, үйлчлүүлэгчдийнхээ итгэлийг даасан хуулийн үйлчилгээ бий болгох”


## Эрхэм зорилго

Бидний эрхэм зорилго нь:


- ▶ Үйлчлүүлэгчдэдээ прагматик, бизнесийн хувьд хэрэгжүүлэх боломжтой хууль зүйн зөвлөгөө өгч, шийдэл олох.
- ▶ Олон улсын стандарт, шаардлагыг хангасан хууль зүйн зөвлөгөө өгөх.
- ▶ Чадварлаг хуульчдыг багтаа элсүүлж, тэднийг цаашид өсөж, хөгжих боломжоор хангах.

## Үнэт зүйлс


- ▶ Хуульчийн ёс зүй, мэргэжлийн ур чадвар.
- ▶ Урт хугацааны, тогтвортой түншлэл.
- ▶ Шинэлэг, үнэ цэн нэмсэн, хариуцлагатай үйлчилгээ.

A photograph showing two people in business attire sitting at a table, reviewing documents and talking. One person is pointing at a document while the other looks on.

Компанийн эрх зүй

A photograph of a person in a suit sitting at a desk, looking at a large document or blueprint spread out on the table.


Гэрээний эрх зүй

A photograph of a construction site with a yellow hard hat, a gavel, and some papers on a table.

Хөдөлмөрийн эрх зүй

A photograph of a stack of books, with the top one open and showing the word "REGULATIONS" on its cover.

Комплайнс

A photograph of a pair of scales of justice and a gavel on a wooden surface.

Иргэний болон  
захиргааны маргаан  
шийдвэрлэх ажиллагаа



## Гүйцэтгэх захирал



### **Мөнхболдын Чингүүн**

Эн Би Кэй хуулийн товчооны партнер М. Чингүүн нь бизнесийн эрх зүй, компанийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн бөгөөд энэ салбарт 12 гаруй жилийн туршлагатай. Тэрээр гадаад, дотоодын бизнес эрхлэгч болон хөрөнгө оруулагчдад Монгол Улсад хэрэгжих томоохон хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрүүдтэй холбоотой гэрээ, хэлэлцээрийн талаар хууль зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн тэрээр Монгол Улсад хамгийн анх удаа байгуулагдсан, АНУ болон Их Британид төвтэй олон улсын хуулийн фирмд ажиллаж Англо-Саксоны хуулийн зөвлөх үйлчилгээ, гэрээ боловсруулалт, ажлын арга барилд суралцсан төдийгүй олон улсын аудитын байгууллагад хуулийн хэлтсийн даргаар ажиллахдаа зээл, хөрөнгө оруулалт, гэрээг татварын эрх зүй талаас судалж, зөвлөгөө өгч ажилласан. Түүнчлэн тэрээр Монгол Улсад хэрэгжсэн томоохон гүний уурхайн бүтээн байгуулалтын төслүүдийн (нийт нэг тэрбум ам.долларын өртөг бүхий) ажил гүйцэтгэх гэрээнүүдийг хариуцан ажиллаж байсан бөгөөд FIDIC болон EPC төрлийн гэрээний хэрэгжилтэд мэргэшсэн туршлагатай.

Ажлын туршлага:

Гадаад харилцааны яам (2011-2012)  
Хоган Ловеллс (2013-2017)  
Прайсуотерхаускуперс (2019)  
Оюу Толгой гүний уурхай (2019 – 2020)  
Эрнст энд янг (2020 - 2022)

Боловсрол:

МУИС, (ОУХ Бакалавр)  
Шихихутуг Их Сургууль, (Бакалавр)  
Вашингтоны Их Сургууль,  
(Хууль зүйн магистр)

Монголын Хуульчдын холбооны гишүүн



## Манай хамт олон

---

Манай хуулийн товчоо нь бизнесийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн хуульчид, хууль зүйн мэргэшсэн орчуулагчид болон хуульчийн туслахуудаас бүрдсэн багтай бөгөөд Монгол, Англи, Хятад хэлээр хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлдэг.

Манай хуульчид компанийн эрх зүй, гэрээний эрх зүй, гадаадын хөрөнгө оруулалт, төслийн санхүүжилт, хөдөлмөрийн эрх зүй, уул уурхай, барилгын эрх зүй зэрэг чиглэлээр олон жилийн туршлага хуримтлуулсан. Бид дотоодын болон гадаадын аж ахуйн нэгжүүдэд хууль зүйн зөвлөгөө өгч, төрөл бүрийн эрх зүйн асуудлыг амжилттай шийдвэрлэн ажиллаж ирсэн.

Түүнчлэн бид гэрээ, эрх зүйн дүгнэлт, компанийн дотоод журам, бодлогын баримт бичиг болон бусад хууль зүйн баримт бичгийг Монгол, Англи хэл дээр мэргэжлийн өндөр түвшинд боловсруулж, хянан баталгаажуулах үйлчилгээ үзүүлдэг. Мөн хууль эрх зүйн чиглэлийн мэргэжлийн орчуулгын үйлчилгээг тогтмол хүргэж байна.

*Манай хуульчид Монголын Хуульчдын Холбооны гишүүд бөгөөд Монгол, Англи, Хятад хэлээр мэргэжлийн түвшинд ажиллах чадвартай.*



## Туршлага

- ▶ Ажил гүйцэтгэх гэрээтэй холбоотой арилжааны арбитрын маргаанд үндэсний болон олон улсын арбитра нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөр оролцож байна.
- ▶ Монгол дахь шинэ төмөр замын томоохон төслийн үндсэн гэрээт гүйцэтгэгчид хууль зүйн зөвлөгөө өгч байна.
- ▶ Хил холбох төмөр замын төслийн үндсэн гэрээт гүйцэтгэгчид хууль зүйн зөвлөгөө өгсөн.
- ▶ Гадаадын мах экспортлогч компанид Монголд салбар нээж, үйл ажиллагаа явуулахад зөвлөсөн.
- ▶ Германы жижиг, дунд үйлдвэрлэгчдэд Монголд хөрөнгө оруулахтай холбоотойгоор зөвлөсөн.
- ▶ Төв Азийн томоохон худалдааны компанид Монгол дахь хөрөнгө оруулалтаар зөвлөсөн.
- ▶ АНУ-д бүртгэлтэй олон улсын хүний нөөц, комплаенсийн компанид Монгол дахь үйл ажиллагаагаар зөвлөсөн.
- ▶ Төв Азид үйл ажиллагаа явуулдаг АНУ-ын уул уурхайн хайгуулын компанид хууль зүйн туслалцаа үзүүлсэн.
- ▶ Хөгжлийн банкны санхүүжилттэй хилийн боомтын дэд бүтцийн төслийн гүйцэтгэгчид гүйцэтгэл баталгаажуулахтай холбоотой зөвлөсөн.
- ▶ Монголын томоохон уул уурхайн төсөлд гэрээгээр оролцох Канадын уул уурхайн компанид зөвлөсөн.
- ▶ Гадаад улсын шүүхийн шийдвэрийг хил дамнасан ажиллагаанд гүйцэтгэхэд туслалцаа үзүүлсэн.
- ▶ Газрын тосны компанид гадаад арбитрын шийдвэрийг Монголд хүлээн зөвшөөрүүлэх, гүйцэтгүүлэхэд зөвлөсөн.
- ▶ Олон гадаад хөрөнгө оруулагчид Монголын уул уурхайн компани худалдан авахад зөвлөсөн.
- ▶ Олон улсын компаниудад Монгол дахь охин компани байгуулах, татан буулгах, төлөөлөгчийн газар бүртгүүлэх, бүртгэлээс хасуулахад туслалцаа үзүүлсэн.

Хууль зүйн үйлчилгээний талаар:  
Утас: +976- 8811-2544  
Имэйл: [ch.munkhbold@nbklegal.com](mailto:ch.munkhbold@nbklegal.com)

Хөдөлмөрийн харилцаа, визний талаар:  
[visa@nbklegal.com](mailto:visa@nbklegal.com)

Хаяг: УБ, БЗД, 26-р хороо, Их Монгол  
Оффис, байр, 302 тоот

Ажлын цаг:

Даваа - Баасан: 10:00 – 17:00